



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГГИЖ БАЙГАА
БОЛОВЧ ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ
ЖУРМЫН НИЙЦЭЛ
АУДИТЫН КОД: /ДУА-2026/14-10-ШТА-НА/**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын
газрын Дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Ихбаяр

Аудитор Б.Мягмарсүрэн

Утас: 7059-2208

Дундговь аймаг 2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох</p> <p>Аудитын менежер Т.Батсайхан Ахлах аудитор Д.Ихбаяр Аудитор Б.Мягмарсүрэн</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70593208 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ:</p> <p>Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот</p> <p>2026 оны 5 дугаар сар</p>	<p>Товчилсон үгс 3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын багийн бүрэлдэхүүн, аудитын дүн, үндсэн мэдээлэл 4-6</p> <p>Тайлан баталгаажуулсан тушаал 7</p> <p>Дүрслэлийн товчөг 8</p> <p><u>БҮЛЭГ : 1. Аймгийн төрийн сангийн хууль тогтоомжоор хүлээсэн зорилт, чиг үүргийг хараат бусаар, бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц бүрдээгүй бөгөөд хүний нөөц, чиг үүрэг, цахим системийн үялдаа алдагдсан байна.</u> 8-19</p> <p><u>БҮЛЭГ : 2. Төрийн сангийн үйл ажиллагаа хууль, журамд нийцэж байгаа ч санхүүжилтийн хугацааны хоцрогдол, төсвийн зохицуулалтын хүндрэл, дотоод хяналтын сүл байдлаас шалтгаалан хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.</u> 19-28</p> <p>Дүгнэлт 29</p> <p>Зөвлөмж 30</p> <p>Үндэсний аудитын газар хүргүүлэх санал 31-33</p> <p>Шалгагдагч байгууллагын санал тайлбар 34</p> <p>Хавсралт 34-39</p>
---	--

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ЗГУМС	Засгийн газрын удирдлага мэдээллийн систем
ТСЦС	Төрийн сангийн цахим систем
СЭЗС	Санхүү эдийн засгийн сайд
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СС	Сангийн сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
СХС	Сум хөгжүүлэх сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ЭБ	Эрхийн бүртгэл
ТАЦНС	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
БОНХОБТХ	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ДУА	Дундговь аймаг
ШТА	Шууд тайлагнах ажил
НА	Нийцлийн аудит

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:*

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу “Төрийн сангийн тогтолцоо, хууль журмын нийцэл”-д ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу нийцлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, хууль журмын нийцэлд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- ✓ Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх;

*Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:*

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Хууль:

- Төсвийн тухай;
- Төсвийн тогтвортой байдлын тухай;
- Засгийн газрын тусгай сангийн тухай;
- Шилэн дансны тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай;

Засгийн газрын тогтоол:

- Төрийн сангийн үйл ажиллагааны журам /2023 оны 444 дүгээр тогтоол/;
- Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам /2021 оны 51 дүгээр тогтоол/;
- Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам /2016 оны 29 дүгээр тогтоол/;

Сангийн сайдын тушаал:

- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт /2012 оны 294 дүгээр тушаал/;
- Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар /2016 оны 431 дүгээр тушаал/;
- “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, “төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал /2025 оны 112 дугаар тушаал/;

Аудитын хамарсан хүрээ:

- “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар” /2024 оны 254 дүгээр тушаал/;
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар /2024 оны 256 дугаар тушаал/;
- Төрийн сангийн цахим системийн заавар /2024 оны 255 дугаар тушаал/;
- Төрийн үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авах журам /Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/131 тоот тушаал/;

Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаал:

- Автомат клиринг хаус системийн дүрэм /2021 оны А-128 тоот тушаал/;
- Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм /2025 оны А-229 тоот тушаал/;
- Монгол банкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм /2022 оны А-135 тоот тушаал/;
- ✓ Төлбөрийн системийн журам /2023 оны А-91 тоот тушаал/
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудитад Монгол Улсад төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, хэрэгжилт, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын төрийн сангийн нэгж, төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн сангийн удирдлагын цахим системийг /цаашид ТСУЦС гэх/ ашигладаг бусад төрийн байгууллагуудын 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, санхүүгийн баримт материал болон бусад нотлох баримт, материалыг хамруулж бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөө, хууль журмын нийцэл, хяналт үнэлгээ хийлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитын асуудлын шинжилгээний 1 дүгээр бүлгийн 1.1.2, 2 дугаар бүлгийн 2.2.1, 2.2.3- д тусгагдсан 4 дэх түвшний асуулт нь аймаг, сумын төрийн санд хамааралгүй тул горим сорил хэрэгжүүлээгүй. Мөн 2 дугаар бүлгийн 2.3.1. болон 2.3.2. дахь

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын дүн

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

асуултууд утга санаа давхацсан тул тайланд мэдээллийг тайланд нэгтгэн тусгалаа.

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Т.Батсайхан үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Б.Мягмарсүрэн нар 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хийж гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 289.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчил арилгуулахаар хугацаатай 6 албан шаардлага, аймгийн СТСХ-ын даргад 4 заалт бүхий зөвлөмж, ҮАГ-аар дамжуулан эрх бүхий байгууллагад 11 заалт бүхий санал хүргүүлээ.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д “*төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг*” гэж тодорхойлж, мөн хуулийн 35, 36, 37, 38 дугаар зүйлд төрийн сангийн нэгдсэн данс, тогтолцоо, нийтлэг чиг үүрэг, Төв болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн чиг үүргүүдийг хуульчилсан байна.

ЗГ-ын 2002 оны 101 дүгээр тогтоолоор төрийн сангийн тогтолцоонд шилжиж аймгийн төрийн сангийн хэлтэс байгуулагдсан байна.

2025 оны байдлаар Дундговь аймгийн төвд Санхүү, төрийн сангийн хэлтэс, 15 суманд Санхүүгийн алба нийт 16 төрийн сангийн нэгж 38 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Бүх шатны төсөв боловсруулах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналыг төсвийн мэдээллийн нэгдсэн сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 2005 оноос төрийн сангийн төлбөр тооцоог ЗГУМС-ээр гүйцэтгэж ирсэн бөгөөд, системийг сайжруулалтыг жил ирэх тусам нэмэгдүүлж төлбөрийн олон хувилбарыг нэвтрүүлсэн байна. Мөн банк хоорондын системийн шинэчлэлтэд төрийн үйлчилгээний төлбөрийг олон хувилбараар төлөх нөхцөлийг бүрдүүлжээ.

Системийг хэрэглэгчээр нь авч үзвэл 2025 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд Эрхийн бүртгэлийн болон Төрийн сангийн удирдлагын цахим системийн хувьд 144 төсвийн байгууллага, 1,048 данс, 303 системийн хэрэглэгч, Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн хувьд 144 төсвийн байгууллага, 3,183 цалин тооцоолж буй төрийн албан хаагч, 260 гаруй системийн хэрэглэгчтэй байна.

Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын нэгжүүд 2025 онд 1,048 бүртгэлийн данс ашиглан нийт 52,593 төлбөрийн хүсэлтээр 272,115.5 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна.



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 01/17

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Эрх шилжүүлэх тухай” 2025 оны А/175 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1, 3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн аудитын тайлан (ДУА-2026/14-10-ШТА-НА)-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (Зөвлөмж, албан шаардлага)-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн нийцлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар заасан хугацаанд Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг аудитын хоёр дугаар нэгжийн ахлах аудитор (Д.Ихбаяр) - т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Т.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

4826010030

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төрийн сангийн салбар нэгжүүдийн 2023-2025 оны гүйлгээний тоо, цагийн ачааллын харьцуулалт түүн дүн	16
Хүснэгт 2	Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олголтын баримт бүрдүүлэлт	23
Хүснэгт 3	Залруулга болон төсвийн зохицуулалтын ялгаатай байдал	23
Хүснэгт 4	Төлбөр тооцоо гүйцэтгэх явцын судалгаа	24
Хүснэгт 5	Төлбөр тооцооны хяналттай холбоотой зөрчлийн судалгаа	25
Хүснэгт 6	Дотоод хяналтын илрүүлэлт	28

Бүдүүвчийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Бүдүүвч 1	Сумын санхүүгийн албаны бүтэц	12

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Цахим системийн хэрэгцээ, хангалтын байдал	18
График 2	Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаар төрийн сан, төсөвт байгууллагын хэрэглэгчээс авсан судалгааны дүн	18
График 3	Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаар төрийн сан, төсөвт байгууллагын хэрэглэгчээс авсан судалгааны дүн	18
График 4	Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаар төрийн сан, төсөвт байгууллагын хэрэглэгчээс авсан судалгааны дүн	19
График 5	Санхүүжилт олголтын судалгаа	21
График 6	Төрийн сангийн хяналттай холбоотой зөрчлийн ангилал, түүний эзлэх хувь	25
График 7	Хаагдсан дансны судалгаа	26
График 8	Дотоод хяналтын илрүүлэлт	28



БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖООР ХҮЛЭЭСЭН ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРГИЙГ ХАРААТ БУСААР, БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ БҮТЭЦ БҮРДЭЭГҮЙ БӨГӨӨД ХҮНИЙ НӨӨЦ, ЧИГ ҮҮРЭГ, ЦАХИМ СИСТЕМИЙН УЯЛДАА АЛДАГДСАН БАЙНА.

1.1 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, журмын зарим заалтууд хоорондоо уялдаагүй хэрэгжүүлэх боломжгүй байна.

1.1.2. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, журмын зарим заалтууд хоорондоо уялдаагүй хэрэгжүүлэх боломжгүй байна.

Төрийн сангийн тогтолцоо, бүтэц, чиг үүрэг, үйл ажиллагаа нь Төсвийн тухай хууль болон ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, ЗГ-ын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоол болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан салбарын сайдын журмаар тус тус зохицуулагдаж байна.

Аудитын явцад төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актуудын зарим заалтууд хоорондоо уялдаагүй, сайжруулах шаардлагатай, хэрэгжүүлэх боломжгүй дараах асуудлууд илэрсэн тул ҮАГ-аар дамжуулан холбогдох байгууллагад уламжлахаар шийдвэрлэлээ. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6.¹, ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.13.2²-д заасан төсвийн байгууллагад амлалтын бүртгэлийг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн сан болон төсвийн байгууллагууд хоорондын харилцааг зохицуулсан журам шинэчлэгдэн батлагдаагүйгээс хууль, журмын дээр заалтын хэрэгжилт хангагдахгүй байна. Тухайлбал СЭЗС-ын 2003 оны 315 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын амлалтын бүртгэлийн тухай түр журам” хүчингүй болж шинэчлэгдэн батлагдаагүй байна. Мөн СС-ын 2024 оны 256 дугаар тушаалаар батлагдсан “ЗГУМС-д мөрдөх заавар”-ын 1.2.14³-т хуульд заасан төлбөрийн амлалтыг бүртгэх талбар системд байхаар заасан боловч одоогоор системд тусгагдаагүй байна.
2. Төсвийн тухай хуулийн 8.9.8.-д орон нутгийн өмчит байгууллагууд аудит хийгдсэн санхүүгийн тайлангаа 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяалагдах ТЕЗ-д хүргүүлж нэгтгүүлэхээр заасан боловч мөн хуулийн 8.9.3-т сумын төрийн сан нь санхүүгийн нэгтгэсэн тайланг 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ гэж заасан цаглаварт хугацаатай уялдаагүй байна.
3. ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.9⁴, 3.4.10⁵-т төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг

¹ "төсвийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон төлбөрийн даалгавартай харьцуулж төлбөрийн амлалтыг бүртгэх;"

² "Төсвийн захирагч нар нь амлалт, үүргийг батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн хүрээнд, зориулалтын дагуу, цаг хугацаанд нь, өр төлбөр үүсгэхгүйгээр бүрэн хэрэгжүүлж ажиллана."

³ "Зардлын амлалтын үүрэг" гэж системд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээний бүртгэл болон түүний дагуу хийгдэх төлбөрийн амлалтыг бүртгэх талбарыг;

⁴ Төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг оролцуулан ажлын 3 өдрийн хугацаанд хүчинтэй байна;

⁵ Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн

- оролцуулан ажлын 3 өдрийн хугацаанд хүчинтэй, мөн төрийн сан төлбөрийн хүсэлтийг ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэхээр заасан боловч ТСЦС /<https://finance.gov.mn/>-д хүчинтэй хугацаа нь амралтын өдрийг оролцуулж 3 өдөр буюу 72 цагаар тооцож байгаа нь журмын заалтын хэрэгжилт хангагдахгүй байна.
4. Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил, үүргийн жишиг заавар”-ын 1.2.18⁶, 1.3.12⁷ -т төсвийн ерөнхий нягтлан бодогч болон мэргэжилтнүүд ажил үүргээ орлож байхаар заасан нь хоорондоо зөрчилдөж байна. Тухайлбал: Төсвийн ерөнхий нягтлан бодогч нь ТЭЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжих төсөл, хөтөлбөр сангийн зарлагын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурах, сар бүр төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох, төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан нэгтгэж баталгаажуулах зэрэг ажлыг бүртгэлийн мэргэжилтэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй боломжгүй, хараат бус байдалд нөлөөлөх зэрэг сөрөг үр дагавартай байна.
 5. ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1.⁸ - д сумын санхүүгийн алба нь 2 нягтлан бодогчтой байхаар журамлаж, 1 нягтлан бодогчид Соёлын төв, ОНХС, СХС, Тусгай зориулалтын сангуудыг хариуцуулан ЗДТГ-ын төсвөөс 100 хувь цалинжуулж байна. Харин 2023 оноос эхлэн соёлын сайдын 3/762 тоот албан бичгээр өсөн чиглэлийн дагуу тус нягтлан бодогч нарт соёлын төвийн төсвөөс албан тушаалын цалингийн 40-50 хүртэл хувиар буюу нийт 255.4 сая төгрөгийн ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл цалин олгож төсвийн хөрөнгийг, үр ашиггүй зарцуулсан байна. Гэвч ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтад одоог хүртэл өөрчлөлт оруулаагүй байгаа нь эрх бүхий байгууллагуудын шийдвэр хоорондоо уялдаа холбоогүй байна.
 6. Төрийн сангаас Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6⁹-д заасны дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” -ын 3.9.2.-т“дотоод хяналт нь эрсдэлд суурилсан зарчмыг баримтална.” гэж заасан боловч СС-ын 2024 оны 254 дүгээр тушаалаар батлагдсан журмын 5.1.1.-д ... “Сум, дүүргийн төрийн сан нь өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж аймгийн төрийн санд хүргүүлнэ” гэсэн нь хороондоо зөрчилдөж байна. Мөн эрсдэл бодитой үнэлэгдэхгүй, хараат бус байдлын зарчим алдагдах, дээд шатны байгууллагын үүргийг сулруулах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй байна. Иймд төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналт шалгалтыг төлөвлөхдөө “эрсдэлийг хараат бусаар бодитой төлөвлөх хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.
 7. Сангийн сайдын 2024 оны 256 дугаар тушаалаар батлагдсан Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар”-ын 3.1¹⁰.-д заасан аймаг, нийслэл, сум дүүргийн “Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн”-ий ажил үүргийн хуваарьт “Зардлын гүйлгээ нэмэх, хасах, устгах, харах хадгалах, хадгалах” гэж заасан

ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана

⁶ Бүртгэлийн мэргэжилтнийг ээлжийн амралттай, чөлөөтэй байх хугацаанд орлох.

⁷ Ерөнхий нягтлан бодогч болон дотоод хяналтын мэргэжилтнийг ээлжийн амралттай, чөлөөтэй байх хугацаанд орлох.

⁸

⁹ Төв төрийн сан нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

¹⁰ Системд нэвтрэх эрх бүхий албан тушаалтан хариуцсан байгууллагын хүрээнд дараах ажил үүргийн хуваарьтай байна.

байгаа нь хэрэгжүүлж байгаа хяналтын чиг үүрэгтэй нь нийцэхгүй байна. Төрийн сангийн мэргэжилтэн нь төсөвт байгууллагаас цахимаар илгээгдсэн төлбөрийн хүсэлтийн анхан шатны баримтын бүрдлийг тулгаж, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн төлбөрийг гүйцэтгэж байгаа тул ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

8. ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, СС-ын 2024 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн цахим системийн заавар”-т төсөвт байгууллагын бүртгэлийн дансны зарлагын гүйлгээ хийх 1 нэгдүгээр гарын үсэг зурах, ТСЦС /<https://finance.gov.mn/>-д нэвтрэх эрхийг олгохдоо холбогдох хууль тогтоомжийн дагуу томилогдсон, эрх олгогдсон албан хаагчид олгохоор заасан байна. Энэ нь хэт ерөнхий тухайн албан тушаалтны хуулийн дагуу томилогдсон эсэхийг нь тодорхойлох боломжгүй, хуульд нийцээгүй шийдвэрээр томилогдсон төсөв захирагчийн гарын үсгээр төсвийн хөрөнгө зарцуулагдах, системийн аюулгүй байдал алдагдах, хариуцлага тооцох боломжгүй болох зэрэг эрсдэлийг бий болгож байна. Тухайлбал: ТАЗ-ийн Дундговь аймаг дахь салбар зөвлөлийн судалгаагаар 2025 оны жилийн эцсийн байдлаар 7 төрийн албан хаагч хуульд нийцээгүй томилгоотой байгаагийн 3 нь төсвийн шууд захирагчийн албан үүргийг гүйцэтгэж байна. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн одоогийн удирдлагыг томилохдоо Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5¹¹ дахь заалтыг үндэслэн аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 03 дүгээр сарын 16-ны өдрийн Б/14 дугаар тушаалаар түр орлон гүйцэтгэгчийг томилсон нь хуульд нийцээгүй томилгоо болсон байна.

Иймд дээрх заалтад нэмэлтээр хууль тогтоомжийн дагуу томилогдсон эсэхийг тодорхойлох нотлох баримтуудын жагсаалт буюу, төрийн албаны салбар зөвлөлийн тодорхойлолт, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон түүний хариу, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, бусад хамааралтай байгууллагын тодорхойлолт гэх мэт зүйлийг авч, томилгоо хууль нийцсэн эсэх нь нотлогдож байгаа тохиолдолд эрх олгох тухай заалтыг тусгаж өгөх шаардлага байна.

1.2 Төрийн сангийн хууль тогтоомжид заасан зорилт, чиг үүргийг хараат бусаар, үр ашигтай хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдээгүй, харин бүтэц, хүний нөөц, чиг үүрэг, цахим системийн үялдаа алдагдсан нь үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна

1.2.1. Төрийн сангийн тогтолцоонд хараат байдал, хууль бус томилгоо болон хүний нөөцийн ачааллын тэнцвэргүй байдал зэрэг бүтцийн болон санхүүгийн эрсдэл үүссэн байна.


Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1¹²-д заасны дагуу аймагт СТСХ, суманд төрийн сангийн нэгж буюу санхүүгийн алба төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Сумдын санхүүгийн албыг Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3¹³ дахь хэсэг болон ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолын дагуу 4 орон тоотойгоор ажиллахаар баталсан байна. *Бүдүүвч № 1*

¹¹ Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

¹² 36.1.Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч/цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

¹³ Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгонд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно.



Жич: Татварын байцаагч нь татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад харьяалагдана.

Харин дээрх хэлтэс, санхүүгийн албад нь тухай шатны ЗДТГ-ын бүтцэд харьяалагдаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2¹⁴ -дахь заалттай нийцээгүй байна.

Төрийн сангийн ажилтнуудын томилгоо болон гүйцэтгэлийн үнэлгээ нь аймаг, сумын ЗДТГ-аас хамааралтай байгаа нь төсвийн сахилга бат, хяналтын функцийг сулруулж, төсвийн хэрэгжилтийг хангах, төлбөр тооцооны гүйлгээ хийх, тайлагнах үйл ажиллагаанд тавих өдөр тутмын хяналтыг хараат бусаар бүрэн хэрэгжүүлж ажиллахад эрсдэл үүсэж байна. Тухайлбал:

- **Ашиг сонирхлын зөрчил:** Төрийн сангийн ажилтан нь төлбөр тооцоонд хяналт тавих үүрэгтэй боловч өөрийг нь томилсон, үнэлдэг Засаг дарга эсвэл ЗДТГ-ын даргын шийдвэрт "Үгүй" гэж хэлэх, хууль бус гүйлгээг зогсоох бодит боломж хязгаарлагдмал (хараат байдал).
- **Төсвийн сахилга бат сулрах:** Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, төсвийн хязгаар хэтрүүлэх эрсдэл нэмэгдэнэ.
- **Мэргэжлийн удирдлага алдагдах:** Сангийн яамнаас өгч буй бодлогын зааварчилгаа орон нутгийн засаг захиргааны шийдвэртэй зөрчилдөх үед төрийн сангийн ажилтан дунд нь "хоёр талын шийдвэрийн дунд гацах" нөхцөл байдал үүсдэг.

Мөн аймгийн Санхүү, төрийн хэлтсийн ажилтнуудыг төсөв санхүүгийн зохицуулалттай холбоотой хууль тогтоомж, заавар журам, программ хангамжийн шинэчлэл, төсөв төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудлаар Сангийн яамнаас өдөр тутам удирдлагаар хангаж, харилцан мэдээлэл солилцон ажиллаж байна.

Иймд дээрх нөхцөл байдлыг судалж СТСХ болон сумын Санхүүгийн алба, эсхүл хяналт тавих эрх бүхий ажилтнуудыг ЗДТГ-ын бүтцээс гаргаж, Сангийн яамны харьяа болгон өөрчилж төрийн сангийн чиг үүргийг хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл боломжоор хангах шаардлагатай байна.

¹⁴ Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сан нь тухайн шатны Захирагчийн ажлын албаны дэргэд байна.

Аймаг, суманд төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлэх 38 орон тоо батлагдсан бөгөөд үүнээс аймгийн СТС-ийн хэлтэс 8 буюу бүрэн орон тоогоор, сумдын хувьд 5 орон тоо /Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн/ дутуу ажиллаж байна. Төрийн сангийн ажилтнуудын дундаас аймгийн СТСХ-ийн 4 болон сумын санхүүгийн албаны 4 төрийн албан хаагч нь үндсэн ажилтайгаа зэрэгцүүлэн бусад ажлыг хавсран, мөн түр орлон гүйцэтгэж байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт- № 1, 2.-аас үзнэ үү./

Үүнээс аймгийн СТСХ-ийн төлбөр тооцоо хариуцсан 2 мэргэжилтний түр орлон гүйцэтгэж байгаа ажил нь томилгооны хувьд хуульд нийцээгүй байна. Тухайлбал:

Гурвансайхан, Дэлгэрцогт, Өлзийт сумд төсөв, төрийн сангийн мэргэжилтний сул орон тоог аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтнээр түр орлон гүйцэтгүүлж, хуульд заасан “тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх” гэх хуулийн зохицуулалтыг буруу хэрэглэж хуульд нийцээгүй шийдвэр гаргаж 18.0 сая төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.¹⁵, 31 дүгээр зүйлийн 31.3.¹⁶, 39 дүгээр зүйлийн 39.1.3¹⁷, 43 дугаар зүйлийн 43.3.3¹⁸-т заасныг зөрчиж, хуулийн зарчмыг алдагдуулж, системийн хэмжээнд буруу жишиг тогтоох сөрөг үр дагавартай байна.

Иймд аймаг, сумын ЗДТГ-ын төсвийн шууд захирагч нар түр орлон гүйцэтгэгчийг хууль, журмын дагуу томилж байх нь зүйтэй бөгөөд зөрчлийг арилгуулахаар дээрх 3 сумын ЗДТГ-ын даргад албан шаардлага хүргүүлээ.

Сайхан-овоо сумын ЗДТГ-ын төсвийн шууд захирагч нь санхүүгийн албаны төсөв, төрийн сангийн мэргэжилтний сул орон тоог 2024-2025 онд тухайн байгууллагын бүтэц, нэгж, тухайн албан тушаалын чиг үүрэгт нь хамааралгүй мэргэжлийн бус “Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан” мэргэжилтнээр түр орлон гүйцэтгүүлэн, хуульд нийцээгүй шийдвэрээр 7.8 сая төгрөгийн цалин хөлс олгосон, 2026 оноос ЗГ-ын тогтоолоор батлагдсан тус орон тоог цомхотгож, ажлыг нь дээрх албан тушаалтанд хавсруулан гүйцэтгүүлж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9.¹⁹, Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5.²⁰, 31 дүгээр зүйлийн 31.3.²¹, 39 дүгээр зүйлийн 39.1.3.²², 43 дугаар зүйлийн 43.3.3²³, ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Санхүүгийн албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны жишиг норматив”-ын 1 дүгээр зүйлийн 1.2²⁴-т заасныг тус тус зөрчсөн байна. Мөн төлбөр тооцоонд тавих хяналтыг сулрах, зөрчилтэй

¹⁵ төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;

¹⁶ Төрийн албан хаагчийг томилох асуудлаар хууль тогтоомж зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

¹⁷ хуульд нийцээгүй шийдвэр гаргах;

¹⁸ энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;

¹⁹ дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох.

²⁰ төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах;

²¹ Төрийн албан хаагчийг томилох асуудлаар хууль тогтоомж зөрчих, түүнчлэн дээрх үйл ажиллагаатай холбогдсон хуурамч тодорхойлолт, гэрчилгээ, баталгаа гаргахыг хориглоно.

²² хуульд нийцээгүй шийдвэр гаргах;

²³ энэ хуулийн 43.3.1, 43.3.2-т зааснаас бусад тохиолдолд албан тушаалтны албан үүргийг тухайн төрлийн албан тушаалын чиг үүрэгт нь хамгийн ойр хамааралтай албан хаагчтай тохиролцсоны дагуу түр орлон гүйцэтгүүлэх;

²⁴ Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

гүйлгээний тоо өсөх, төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, мэдээллийн аюулгүй байдлын журам зөрчигдөх, тайлан мэдээ буруу гарах, ажлын хариуцлага сулрах зэрэг сөрөг үр дагавартай байгаа тул зөрчлийг таслан зогсоож, хууль журамд нийцүүлэх асуудлаар ЗДТГ-ын даргад албан шаардлага хүргүүлжээ.

Сул орон тоог түр орлон гүйцэтгүүлэхтэй холбоотой дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд орон тооны илүүдэл ба ачааллын тэнцвэргүй байдал, бүтцийн үр ашиггүй байдал бий болсон гэж дүгнэж болох талтай байна. Тухайлбал: Аудитын явцад хийсэн шинжилгээгээр сумдын төрийн сангийн ачаалал аймгийн төвийнхөөс гүйлгээний тоогоор 10.9 дахин, зарцуулах хугацаагаар 1.5 дахин бага байна. Аймгийн мэргэжилтнүүд өөрийн үндсэн ажилтай зэрэгцүүлэн 1-2 сумын ажлыг гүйцэтгэж байгаа нь аймгийн төвд тухайн 2 орон тоо заавал байх шаардлагатай эсэхийг бодлогын түвшинд судлах хэрэгтэй байгааг илтгэж байна. Энэхүү ачааллын тэгш бус байдал нь хүний нөөцийг зохисгүй хуваарилсныг илэрхийлэх бөгөөд цаашид аймаг, сумдын төрийн сангийн үйл ажиллагааг цахимжуулах замаар цомхотгож, орон тоог цөөлөх үндэслэл болохоор байна.

1.2.2. Орон нутгийн Төрийн сангийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт бодит чиг үүрэгтэйгээ нийцээгүй, зарим суманд хууль бус болон хамааралгүй ажил үүрэг давхардуулсан зөрчилтэй байгаа төдийгүй сумдын ажлын ачаалал тэнцвэргүй байна.

Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд төрийн сангийн нийтлэг чиг үүргийг СС-ын 2015 оны 90 дүгээр тушаалаар Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажлын чиг үүргийн жишиг зааврыг баталсан байна. Харин сумын санхүүгийн албаны ажилтнууд ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолын хавсралтаар баталсан ажлын чиг үүргийн жишиг зааврыг дээрх журамтай давхар мөрдөж байна. Төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давхардаагүй байна.

Орон нутгийн төрийн сангийн хэлтэс, албадын чиг үүргийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй шинэчлэн сайжруулах дараах асуудлууд байна. Тухайлбал:

- “Санхүүгийн алба байгуулах тухай” ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолын 1.2.4.-т төсөв, төрийн сангийн мэргэжилтэн “Статистик мэдээ гаргах” ажлыг давхар гүйцэтгэхээр зааж өгсөн нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүрэгт хамааралгүй ажил үүргийг хариуцуулсан байна.
- Орон нутагт төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, бүртгэх тайлагнах, санхүүжүүлэх, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг аймгийн ЗДТГ-ын СТСХ, сумдын санхүүгийн алба хэрэгжүүлж байгаа нь төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөж, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг санхүүжүүлэх, төсвийн зарлагын дарааллыг журмын дагуу тогтоох, бүлэглэсэн дүнгээр хяналт тавих үндсэн чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл хангагдахгүй байна.

Аймгийн төрийн сангийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг ТА3-ийн 2019 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан жишиг загварын дагуу, сумын төрийн сангийн ажилтнуудын хувьд 2025 онд шинэчлэгдсэн ТА3-ийн 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан загварын хүрээнд боловсруулан аймаг, сумын ЗДТГ-ын даргаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Аудитын явцад төрийн сангийн ажилтнуудаас авсан санал асуулгын “Таны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг уу” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 88.9 хувь буюу 32 нь “***Бүрэн нийцдэг***”, 11.1 хувь буюу 4 нь “***Нийцдэггүй***” гэж хариулсан байна.

Харин “Ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй өөр чиг үүргийг хэрэгжүүлдэг үү” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 75 хувь буюу 27 нь “Үгүй”, 15 хувь буюу 9 нь “Тийм” гэж хариулсан байна. Тийм гэж хариулсан ажилтнуудын хувьд цаг үеийн шинжтэй байгууллагын бусад ажил, түүнтэй холбогдолтой бусад мэдээ тайлан, хэрэгжилт, орон тооны бус зөвлөл, дэд хорооны гишүүн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг хүлээн авах комиссын гишүүн гэх мэт ажлыг нэмэлтээр хэрэгжүүлдэг тухай дурдсан байна.

Төрийн сангийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолт уялдаагүй, албан тушаалын тодорхойлолтод тухайн албан тушаалын ажлын чиг үүрэгт хамааралгүй ажил үүргийг тусгаж баталсан байгаа тул ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг ажилтны чиг үүрэгтэй холбоотой шинэчлэгдсэн хууль, журамд нийцүүлэн боловсруулж, нэг бүрчлэн хянаж, батламжлах шаардлагатай байна. Үүнд:

- Төрийн сангийн бүртгэлийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22-т заасан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг чиг үүргийг тусгаж өгөөгүй, иймээс бүртгэлийн мэргэжилтэн дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчлийг шийдвэрлэж чадахгүй байна байна. *Тухайлбал: Орон нутгийн 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нэр дэвшигч нарын, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй зөрчилд, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч төрийн аудитын байгууллагад нотлох баримтыг ирүүлээгүй байна.*
- Сумдын санхүүгийн албаны дарга болон төрийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод чиг үүрэг нь хамааралгүй, журмаар шинэчлэгдэж хамааралгүй болсон дараах ажлуудыг тусгаж баталсан байна. Тухайлбал ;
 - ✓ *Төсвийн тухай хуулийн дагуу нэмэлт төсвийн эрхийг төсвийн байгууллагад хянан олгох,*
 - ✓ *Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг болон холбогдох үйл ажиллагааны тайлан мэдээг боловсруулах, нэгтгэн тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх хууль*
 - ✓ *Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах*
 - ✓ *Төсөвт байгууллагуудын жижиг мөнгөн сангийн тайланг хянах*
 - ✓ *Төсвийн төлөвлөлтийн мэдээллийн системд сумын төсвийн байгууллага бүрийн төсвийн хязгаарыг үүсгэх, төслийн нэгтгэлийг хүлээн авч, хянах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, батлагдсан төсвийг байгууллага бүрд хүргүүлэх*
 - ✓ *Мемориалын ордерын 1 дүгээр гарын үсэг зурах, төрийн сангийн өдрийн гүйлгээний мемориалын баримтыг баталгаажуулан гарын үсэг зурах, хянан баталгаажуулах*
 - ✓ *Сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтад 2 дугаар гарын үсэг зурж, тайлан баланс гаргах*

Төрийн сангийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь, албан тушаалын тодорхойлолт уялдаагүй, албан тушаалын тодорхойлолтод тухайн албан тушаалын ажлын чиг үүрэгт хамааралгүй ажил үүргийг тусгаж баталсан дээрх зөрчлийг арилгуулахаар аймгийн СТСХ-т зөвлөмж хүргүүлээ.

Аудитын явцад төрийн сангийн салбар нэгжүүдийн 2023-2025 оны гүйлгээний тоо, цагийн ачааллыг харьцуулан шинжилж, хүний нөөцийн хуваарилалт болон үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх шийдэл боловсрууллаа.

Хүснэгт: №1 Өгөгдлийн харьцуулсан үзүүлэлт

Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он	Хандлага
Нийт гүйлгээ (Өдрөөр)	281	315	255	2024 онд дээд түвшиндээ хүрч, 2025 онд буурсан
Цагийн дундаж ачаалал	35.1	39.4	31.9	Ерөнхийдөө тогтвортой
Хамгийн өндөр ачаалалтай	Сайнцагаан	Сайнцагаан	Сайнцагаан	Бусад сумаас 3-4 дахин их
Хамгийн бага ачаалалтай	Баянжаргалан, Говь-Угтаал	Цагаандэлгэр	Говь-Угтаал, Цагаандэлгэр	Өдөрт 7-9 гүйлгээ

Дээрх хүснэгтээс аймаг, сумын төрийн сангийн ажлын ачааллын тэнцвэргүй байдлаас төсвийн үр ашиггүй зарцуулалт хийгдэж байна гэж дүгнэж болохоор байна. Тухайлбал: Сайнцагаан сум нь өдөрт дунджаар 31-34 гүйлгээ (цагт 3.8-4.2) шалгадаг бол бусад сумууд дунджаар 8-14 гүйлгээ (цагт 1.0-1.7) гүйцэтгэж байна. Энэ нь Сайнцагаан сумын мэргэжилтнүүд бусад сумдаас олон байгууллагатай боловч адилхан 1 мэргэжилтэнтэй ажиллаж байгаа учир 3 дахин илүү ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт - № 3-аас үзнэ үү./ Аймгийн төвийн онцлог: Аймгийн төв нь хамгийн өндөр ачаалалтай буюу өдөрт дунджаар 86-110 гүйлгээ хийдэг ч хянах мэргэжилтний тоо (2) нь сумуудаас (1) их байгаа нь зохистой харьцаа юм. Гэсэн хэдий ч цагийн ачаалал нь 10.8 - 13.8 байгаа нь сумуудтай харьцуулахад маш өндөр байгаа боловч мэргэжилтнүүд өөрийн үндсэн ажилтай зэрэгцүүлэн 1-2 сумын ажлыг давхар гүйцэтгэж байна. Ачааллын өсөлт бууралтын хувьд 2025 онд нийт гүйлгээний тоо өмнөх онтой харьцуулахад 19 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь цахим шилжилт болон төсвийн төвлөрүүлэлт, хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбоотой байна. Мөн сумын төрийн сангийн төлбөр тооцоо нь хянах, батлах 2 шатлалтай хийгдэж байгаа нь ажил үүргийн хувьд үр дүнгүй шат дамжлага нэмэгдүүлж, ажлын ачааллыг тэгш бус хуваарилсан байна.

Иймд аймаг, сумын төрийн сангийн ажилтнуудын ажлын ачааллын харилцан адилгүй байдал, ажилтнууд өөрийн ажилтай зэрэгцүүлэн давхар ажил эрхэлж байгаа байдлыг судалж цаашид одоогийн бүтэц орон тоогоор ажиллах шаардлагатай эсэхийг тооцож одоогийн орон тоог бууруулж, бага зардлаар төрийн сангийн үйл ажиллагааг хууль, журмын дагуу чанартай хэрэгжүүлэх шийдлийг гаргаж ажиллах нь зүйтэй байна.

Аймаг, сумын Төрийн сангийн ажлын ачааллын тэнцвэргүй байдлыг арилгах, урсгал зардлыг хэмнэх, хяналтын чанарыг сайжруулах зорилгоор цаашид дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- **Тогтмол зардлын гүйлгээг автоматжуулах:** Цахим шилжилтийн хүрээнд технологийн шинэчлэл хийж, ачаалал багатай (өдөрт 1–2 гүйлгээ ногддог) сумдын албан томилолтын зардал, бичиг хэрэг болон шуудан харилцааны зардал, тог цахилгаан, холбоо (утас, интернет)-ны төлбөр, татвар шимтгэл төлөлт зэрэг давтагддаг тогтмол гүйлгээнүүдийг системээр автоматжуулж, хүний хүчин зүйлийн оролцоог бууруулах;

- **Эрсдэлд суурилсан хяналтын системд шилжих:** Бүх гүйлгээг нэг бүрчлэн шалгадаг одоогийн практикийг өөрчилж, бага үнийн дүнтэй, эрсдэл багатай гүйлгээг системээр шууд батлах, харин өндөр үнийн дүнтэй гүйлгээг нарийвчлан хянадаг ухаалаг системд шилжих;
- **Бүсчилсэн зохион байгуулалт хийх:** Газар зүйн байршлын хувьд ойр орших, ажлын ачаалал багатай сумуудын Төрийн сангийн нэгжүүдийг бүсчилж нэгтгэх замаар урсгал болон удирдлагын зардлыг хэмнэх боломжийг судалж, шийдвэрлэх;
- **Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх:** Төрийн сангийн мэргэжилтнүүдийн ажлын бүтээмж, хурдыг нэмэгдүүлэх зорилгоор техник хангамжийн шинэчлэл хийх, программын ахисан шатны мэдлэг олгох сургалтуудыг үе шаттай зохион байгуулах.

Дээрх дижитал шинэчлэл болон бүтцийн өөрчлөлтийг хийснээр Төрийн сангийн хүний нөөцийн дутагдал болон хэт ачааллыг тэнцвэржүүлж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой юм.

1.2.3. Төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчдийн ажлын үндсэн хэрэгцээг хангаж, аюулгүй байдал, ашиглахад хялбар байдлын хувьд зохих түвшинд байгаа боловч дутуу хөгжүүлэлт, интернэтийн хамаарал, цаасан баримтын давхардал, систем хоорондын уялдаа сул байна.

Төрийн сангийн үйл ажиллагаанд ТСУЦС, ТАЦНС, ЭБ-ийн гэсэн 3 системийг ашиглаж байна. Дээрх системд төрийн сангийн ажилтан, төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогч нар өөрт тусгайлан олгогдсон эрхээр нэвтэрч төрийн сангийн гүйлгээг хийх, хянах, баталгаажуулах үйлдлийг гүйцэтгэж байна. Сангийн яамнаас хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбогдуулан системд хийж байгаа шинэчлэлийн талаарх сургалт мэдээллийг <http://surgalt-ts.mof.gov.mn/> цахим хуудсаар дамжуулан хэрэглэгч хүргэсэн байна.


Аудитаар төрийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй системийн доголдол, найдвартай байдлын асуудал горим сорил хэрэгжүүлсэн боловч эдгээрээс шалтгаалсан төсвийн санхүүжилтийн эрх олголт, төсөвт байгууллагуудын зарлагын гүйлгээ тасалдах, саатах зэрэг ноцтой алдаа, зөрчил бүртгэгдээгүй байна.

Аудитын явцад төрийн сангийн ажилтнуудын цахим системийн ашиглалт, хүртээмж, уялдаа холбоо, найдвартай байдалтай танилцаж, төрийн сан болон төсөвт байгууллагын хэрэглэгчдээс авсан санал асуулгын үр дүнд дараах саналуудыг нэгтгэн гаргав. Үүнд:

Төрийн сангийн цахим системийн ашиглалт, хүртээмж, найдвартай байдлын талаар төрийн сан болон төсөвт байгууллагын хэрэглэгчээс авсан санал асуулгын дүн:

Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаарх судалгаанд төрийн сангийн хэрэглэгч буюу хянах 17, батлах 16 нийт 33 ажилтан 100 хувь, төсөвт байгууллагын нийт хэрэглэгчийн /Байгууллагын дарга, нягтлан бодогч/ 53.1 хувь буюу 153 хэрэглэгч хамрагдсан байна.

График № 1




Судалгаагаар “Төрийн сангийн үйл ажиллагааг явуулахад цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ? гэсэн асуултад нийт хэрэглэгчдийн 58.6 хувь нь **“Бүрэн”**, 41.4 хувь нь **“Хэвийн”** хангаж байна гэсэн хариулт өгчээ.

График № 1

Цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ? гэсэн асуултад төрийн сангийн хэрэглэгчдийн 87.9 хувь нь **“Интернэтийн саатал”**, 6.1 хувь нь **“Программ тасалдал буюу тоног төхөөрөмж”**, 6.1 хувь нь **“Бэрхшээл гардаггүй”**

гэж хариулсан байна. Төсөвт байгууллагын хэрэглэгчдийн 52.9 хувь нь **“Интернэтийн саатал”**, 16.4 хувь нь **“Программ тасалдал буюу тоног төхөөрөмж”**, 30.7 хувь нь **“Бэрхшээл гардаггүй”** гэж хариулсан байна.

График № 2



Төрийн сангийн үйл ажиллагааг цахим систем ашиглан **“орон зай үл хамааран”** гүйцэтгэх боломжтой эсэх болон “Төрийн сангийн ажлыг гүйцэтгэхэд цахим системээс гадна цаасан суурьтай баримт үйлддэг үү? гэсэн асуултад төрийн сангийн нийт хэрэглэгчид 100 хувь **“Тийм”** гэж

хариулсан байна.

График № 3



Төрийн сангийн цахим системийн **“аюулгүй байдал”** хангагдсан гэж үзэж байгаа юу гэсэн асуултад төрийн сангийн хэрэглэгчид 100 хувь **“Тийм”** гэж хариулсан бол төсөвт байгууллагын хэрэглэгчдийн 71.2 хувь нь **“Тийм”**, 4.6 хувь нь **“Үгүй”**, 24.2 хувь нь **“Мэдэхгүй”** гэж хариулсан байна.

График № 3 Төсөвт байгууллагын хэрэглэгчдээс авсан “Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар байна уу?” гэсэн асуултад

хэрэглэгчдийн 97.4 хувь нь **“Тийм”**, 2.6 хувь нь **“Үгүй”**, “Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой

График № 4



ажиллаж чадаж байна уу?” гэсэн асуултад хэрэглэгчдийн 71.2 хувь нь “Тийм”, 13.7 хувь нь “Үгүй”, “Системд үүссэн асуудлыг систем хариуцагч байгууллагын зүгээс бүрэн, шуурхай шийдвэрлэдэг үү?” гэсэн асуултад хэрэглэгчдийн 73.2 хувь нь “Тийм”, 22.2 хувь нь “Удаан”, 4.6 хувь нь “Үгүй”, гэж тус тус хариулсан байна.

График № 4

Төрийн сан болон төсөвт байгууллагын хэрэглэгчид цахим системд сайжруулалт хийх асуудлаар дараах саналыг өгсөн байв. Үүнд:

Төрийн сангийн хэрэглэгч :

- Төсвийн гүйцэтгэлийн мэдээлэл авах зорилгоор төрийн сангийн цахим систем finance.gov.mn сайтаас төсвийн байгууллагын хуулга, бүлэгтэй тайланг харах тохиргоотой боловч систем хөгжүүлэлт дуусаагүй, төсвийн мэргэжилтний эрхийн бүртгэл дээр ямар ч функц ажилладаггүй.
- Системээр төсөвт байгууллагын ажилчдын цалингийн гүйлгээ хянахад цалингийн хүснэгтэд ажилчдын нэмэгдэл цалин төрөл тус бүрээр харагддаггүй, нийт дүнгээр харагдаж цалин дахин тооцоолж хянах шаардлагатай байгууллагаас цалингийн хүснэгтийг цаасаар авах шаардлага бий үүсдэг.
- Төрийн сангийн цахим системд орон нутгийн төсвийн төлөвлөлтийн мэдээллийг оруулах боломжтой болгож төсвийн төлөвлөлтийг цахим болгох
- Төрийн сангийн цахим системийн шинэчлэлтэй холбоотой мэдээллийг албан хаагчдад сургалтын агуулга шинж чанараас хамааран танхим болон цахим хэлбэрээр хослуулан хийх.

Төсөвт байгууллагын хэрэглэгч :

- Байгууллагын санхүүгийн мэдээлэл цөөн хүний дамжлагаар гүйлгэгддэг хэдий ч QR кодтой мэдээлэл хяналтгүй тархаж байна. Үүний нэг жишээ нь ажилчдын урамшууллын тушаалыг программаас хэвлэн тарааснаар олон нийтийн сүлжээнд нийтлэгдэж, байгууллагын удирдлага болон албан хаагчдад нягтлан бодогч мэдээлэл задруулсан мэт буруу ойлголт үүссэн явдал юм. Иймд төрийн сангийн ажилтнууд нууцын баталгаа хийх шаардлагатай байгаа нь ажиглагдсан.
- Системийн хүчин чадлыг сайжруулах, санхүүжилтийн залруулга хийх үйлдлийг илүү сайжруулах
- Шинэчилсэн мэдээ мэдээллээ тухай бүр мэдээлэн арга зүйн зөвлөмж өгч хэвших
- Шинэ удирдлага даргад сургалт зөвлөгөө маш дутмаг, жил бүр сургалт зохион байгуулж мэдээллээр хангах
- Сарын эцэст болон жилийн эцэст хандалт ихэссэн үед орохгүй байх, алдаа заадаг.
- Шилэн дансны системийг төрийн сангийн системтэй бүрэн холбож өгөх
- Өглөг авлагын нэгтгэлийг сайжруулж сар бүр өссөн дүнгээр орон нутаг улсын төсвөөр гардаг болгож сайжруулах

- *Нэмэлт санхүүжилтийн зарцуулах эрхийг нэг удаагийн хүсэлтээр өөр өөр хөтөлбөр зориулалт тус бүрээр нээх боломжгүй байгаа үүнийг нэг удаагийн хүсэлтээр хөтөлбөр, зориулалт тус бүрээр эрх нээдэг болгож сайжруулах”*

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилын үр дүн санал асуулгын дүнгээс харахад Төрийн сангийн цахим систем нь төрийн сангийн хэрэглэгчдийн хувьд хүртээмж, аюулгүй байдал хангагдсан ч дутуу хөгжүүлэлт, цаасан баримтын давхардал зэрэгт анхаарал хандуулж системийн сайжруулалт, журамд нэмэлт өөрчлөлтийг хийх шаардлагатай байгааг харуулж байна.



БҮЛЭГ 2. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦЭЖ БАЙГАА Ч САНХҮҮЖИЛТИЙН ХУГАЦААНЫ ХОЦРОГДОЛ, ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХҮНДРЭЛ, ДОТООД ХЯНАЛТЫН СУЛ БАЙДЛААС ХЭРЭГЖИЛТ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

2.1. Төсвийн санхүүжилт, болон зарцуулалтын эрх олгох үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцээгүй, журмын хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

2.1.1. Орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт төлөвлөгөөний дагуу бүрэн олгогдож байгаа боловч санхүүжилтийг олгох хугацааны хувьд холбогдох журмын хэрэгжилт бүрэн хангагдахгүй, үйл ажиллагааны дараалалтай холбоотой саатал үүсэж байна.


Аймгийн төрийн сан нь орон нутгийн төсвөөс ТЕЗ-ын байгууллагуудад олгосон санхүүжилт болон сумдад олгосон татаасыг 2023-2025 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу баталгаажсан маягтаар бүрэн олгож ирсэн байна. *График - № 5*

Харин санхүүжилтийг сар бүрийн ажлын эхний 5 хоногт багтаан олгоогүй бөгөөд энэ нь сар бүрийн зарцуулалтын эрх татагдсаны дараа санхүүжилт олгогддог үйл ажиллагааны дараалалтай холбоотой байна.

Иймээс ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6.1²⁵-дэх заалтын хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна.

²⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор олгоно, мөн энэ журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно

График № 5 Санхүүжилт олголтын судалгаа /сая.төг/



Санхүүжилтийг хугацаанд нь олгоогүйгээс төсөвт байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа саатах, цалин хөлс болон урсгал зардлын санхүүжилт тасалдах, улмаар төлбөр тооцоо хугацаандаа хийгдэхгүйгээс өр төлбөр үүсэх эрсдэл бий болно.

Цаашид зарцуулах эрх татах үйл явцыг сарын өмнөх хугацаанд урьдчилан зохион байгуулж, төлөвлөлт, баталгаажуулалт, эрх нээлтийн ажиллагааг уялдуулснаар санхүүжилтийг сар

бүрийн ажлын эхний 5 өдөрт багтаан олгох боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

2.1.2. Төсвийн зарцуулалтын эрх олголт журмын дагуу хэрэгжиж байгаа ч дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр төсөвт зохицуулалт хийсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвийн сар, улирлын хуваарийг оны эхэнд болон оны эцэст мөн төсөвт тодотгол хийсэн тохиолдолд батлуулж, төсвийн нэгтгэлийн программ болон ЗГУМС -д оруулсан байна. Төсвийн шууд захирагчийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарьт төсвийн жилийн дундуур хийж буй зохицуулалтыг аймаг, сумдын төсвийн захирагчийн шийдвэр, зөвшөөрөлгүй, төсөвт зохицуулалт хийх шаардлага, нарийвчилсан тооцоо тайлбаргүйгээр хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4²⁶, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.2²⁷, 3.2.²⁸, 3.2.3²⁹ - дахь заалтуудыг зөрчсөн байна.

Холбогдох дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй, нарийвчилсан тооцоо, судалгаанд үндэслэхгүйгээр төсөвт өөрчлөлт оруулснаар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, оны эцэст өр төлбөр үүсэх зарим зардлын санхүүжилт тасалдах үр дагавартай.

Иймд төсвийн зохицуулалт нь зөвхөн тоон үзүүлэлтийг өөрчлөх үйлдэл бус, харин хууль, тогтоомжид нийцүүлэн гарсан шийдвэрт хамаарах тул эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн шийдвэр, тооцоололд үндэслэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгох журам:

Барьцаа хөрөнгийн дансанд тухайн онд гүйцэтгэгчид олгогдоогүй төсөл, арга хэмжээний санхүүжилт болон бүрэн хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний чанарын баталгааг байршуулдаг. Тухайн онд гүйцэтгэгчид олгогдоогүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эрхийг нээхдээ төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр захиалагчаас Сангийн яам руу баталгаажуулан илгээж эрх нээлгэсний дараа санхүүжилтийг гүйцэтгэгч, зохиогч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудад шилжүүлдэг. Чанарын баталгааг барилга байгууламжийн зүгшрүүлэн, тохируулах хугацаа дууссаны дараа

²⁶ Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна.
²⁷ Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх санал нь дараах агуулгатай байна.
²⁸ Холбогдох төсвийн захирагчийн шийдвэр, зөвшөөрөл
²⁹ Төсөвт зохицуулалт хийх шаардлага, нарийвчилсан тооцоо тайлбар

ашиглагч, захиалагч, зохиогч, захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байгууллагуудын хурлын тэмдэглэл, албан бичигт үндэслэж барьцаа хөрөнгөөс чөлөөлөх эсэхийг шийдвэрлэж байна.

Шалгагдсан хугацаанд 2023 онд 158.5 сая төгрөг, 2024 онд 1,174.5 сая төгрөг, 2025 онд 2,040.4 сая төгрөгийн санхүүжилт болон чанарын баталгааг тус тус олгож, тайлант хугацааны эцэст 501.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 2023, 2025 онуудад хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс барьцаа хөрөнгийн дансанд санхүүжилт байршуулаагүй, 2024 онд 3 төсөл, арга хэмжээний 62.6 сая төгрөгийг байршуулсан байна.

Захиалагчийн хяналтын зардлын эрх олгох журмын хэрэгжилт:

Аймгийн хэмжээнд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын захиалагчийн хяналтын зардлыг аймгийн “Техник хяналтын зардлын данс”-д төвлөрүүлж, аймгийн Засаг даргын 2016 оны А/142 дугаар захирамжаар олгосон эрхийн дагуу ГХБХБГ-ын дарга, нягтлан бодогчийн гарын үсгээр захиран зарцуулж байна.

Төрийн сангаас тайлант оны эхэнд тус сангийн төсөвлөсөн эх үүсвэрийн хүрээнд зарцуулалтын эрхийг тус зардлыг зарцуулах журам, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрхийг нээж зарцуулалт хийгдэж байна.

Аймаг, суманд улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын захиалагч буюу төсөв захирагч нар захиалагчийн хяналтыг ЗГ-ын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “***Барилгын ажлын захиалагчийн дүрэм***”-ын 3 дугаар зүйлийн 3.12³⁰.-г заасны дагуу аймгийн ГХБХБГ-аар гэрээгээр гүйцэтгүүлж санхүүжилтийг олгож байна.

ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.10.5³¹ -д захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ хэрэгжсэний дараа захиалагчийн хяналтын үлдэгдэл санхүүжилтийг тухайн төсвийн жилд багтаан улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр заасан боловч 2023-2025 онд хэмнэлт гараагүй тул төвлөрүүлэлт хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олгох журам:

Төсвийн байгууллагууд ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.12.2³²-г заасны дагуу төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн зарцуулах эрхийг нээлгэх хүсэлтийг аймгийн төрийн санд хүргүүлж байна.

Аймгийн төрийн сан төсөвт байгууллагын нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийг эх үүсвэрийг нь нотлох баримтгүйгээр (тушаал, шийдвэр, гэрээ) зөвхөн батлагдсан маягтыг

³⁰ Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

³¹ Төсвийн захирагч нь захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ хэрэгжсэний дараа захиалагчийн хяналтын үлдэгдэл санхүүжилтийг тухайн төсвийн жилд багтаан улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

³² Төсвийн байгууллага нь нэмэлт төсвийн зарцуулалтын эрх нээлгэх хүсэлтийг дараах баримт бичгийн хамт цахимаар, эсхүл албан бичгээр харьяалагдах төрийн санд хүргүүлнэ:

үндэслэн нээж, журам зөрчин анх нээсэн зарцуулалтын эрх буюу хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилалд өөрчлөлт оруулж, залруулга хийж байна.

Хүснэгт № 2 Нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олголтын баримт бүрдүүлэлт

Огноо	Гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэр (Эх үүсвэр нотлох баримт)	Төсвийн захирагчийн шийдвэр (Хөрөнгө зарцуулах эрх нээлгэх)	Нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлт (32 дугаар хавсралт)
2023 он	145	1,786.8	✗ Дутуу (Дээд шатны байгууллагын шийдвэр, нотлох баримт дутуу)	✗ Дутуу (Төсвийн шууд захирагчийн шийдвэр дутуу)	✓ Бүрэн (Батлагдсан маягтаар эрх нээсэн)
2024 он	206	2,807.7	✗ Дутуу (Дээд шатны байгууллагын шийдвэр, нотлох баримт дутуу)	✗ Дутуу (Төсвийн шууд захирагчийн шийдвэр дутуу)	✓ Бүрэн (Батлагдсан маягтаар эрх нээсэн)
2025 он	112	2,372.0	✗ Дутуу (Дээд шатны байгууллагын шийдвэр, нотлох баримт дутуу)	✗ Дутуу (Төсвийн шууд захирагчийн шийдвэр дутуу)	✓ Бүрэн (Батлагдсан маягтаар эрх нээсэн)
2025 оны 10 сараас (цахим)	129	746.9	✓ Бүрэн (Дээд шатны байгууллагын шийдвэр, нотлох баримт оруулсан)	✓ Бүрэн (Төсвийн шууд захирагчийн шийдвэр оруулсан)	✓ Бүрэн (Батлагдсан маягтаар эрх нээсэн)
Нийт дүн	592	7,713.4	-	-	-

Хүснэгтээс харахад 2023–2025 онд төсвийн байгууллагуудад нэмэлт төсвийн зарцуулалтын эрх олголтын баримт бичгийн бүрдүүлэлтийг дараах байдлаар хийсэн байна. Үүнд:

- 2023–2025 оны хугацаанд буюу цахимжихаас өмнө дээд шатны байгууллагын шийдвэр, гэрээ зэрэг эх үүсвэр нотлох баримт дутуу, төсвийн шууд захирагчийн хүсэлт дутуу, зөвхөн батлагдсан маягтаар зарцуулалтын эрх нээсэн.
- 2025 оны 10-р сараас хойш буюу цахим систем нэвтэрснээр баримт бүрдүүлэлт сайжирч, журамд нийцүүлэн зарцуулах эрх нээсэн байна

Энэ нь Төсөвт байгууллагууд нэмэлт данс нээлгэхдээ СС-ын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөөгүйгээс орлого, зардлын ангилал зөрүүтэй үүсэж залруулахдаа нэмэлт санхүүжилтийн эрхийн хүсэлтийн маягтаар зардал хооронд гүйлгэн залруулга хийж байгаа нь хууль, зүйн үндэслэлгүй байна. *Хүснэгт № 3*

Хүснэгт № 3 Залруулга болон төсвийн зохицуулалтын ялгаатай байдал

Үйлдэл	Эрх зүйн үндэслэл	Шаардагдах баримт
Техникийн залруулга	ЗГ-ын 2023 оны 444-р тогтоол	Залруулгын маягт, алдааг нотлох баримт
Зардал хоорондын шилжүүлэг	Төсвийн тухай хуулийн 42-р зүйл Сангийн сайдын 2018 оны 134-р тушаал	Төсөвт зохицуулалт хийхийг хүссэн албан бичиг, холбогдох төсвийн захирагчийн шийдвэр, зөвшөөрөл, шаардлага, нарийвчилсан тооцоо тайлбар

Иймд нэмэлт төсвийн эрхийг, нэмэлт орлогыг зарцуулах хууль журамд заасан хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу нээлгэж, хөтөлбөр зориулалтыг дахин өөрчлөхгүй, зориулалтын дагуу зарцуулах шаардлагыг тавьж журмын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

2.2 Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагааны хүрээнд гүйлгээнд тодорхой түвшинд хяналт тавигдаж байгаа боловч хяналтын үр нөлөө хангалтгүй, улмаар гүйлгээний бодит байдал, баримтын нийцэлд тавих хяналт сүл байна.

2.2.2. Аймгийн төрийн сангийн гүйлгээний хяналт хангалттай хэмжээнд хийгдэж байгаа ч төлбөр тооцоонд тавих хяналт сүл, ялангуяа хөрөнгө оруулалтын гүйлгээнд анхан шатны баримтад суурилсан хяналт хангалтгүй байна.

Төсөвт байгууллагын дарга, нягтлан бодогч нарын гарын үсгийн баталгаажуулалт болон бусад холбогдох баримт бичгийг цаасан хэлбэрээр хүлээн авч, хянан баталгаажуулсны дараа ТСУЦС-д бүртгэл үүсгэн хэрэглэгчийн эрх авах хүсэлтийг илгээж, байгууллагын данснуудад баримт бичгийн тохиргоог хийж гүйцэтгэсэн байна. 2023-2025 онд шинээр томилогдсон төсөвт байгууллагын албан хаагчдын мэдээллийг системд шинээр бүртгэн тохиргоо хийж, чөлөөлөгдсөн албан хаагчдын эрхийг цуцалж, системээс хасах ажлыг журмын дагуу хийсэн байна. Хүснэгт № 4

Хүснэгт № 4 Төлбөр тооцоо гүйцэтгэх явцын судалгаа

Үзүүлэлт	2023 он			2024 он			2025 он		
	Гүйлгээ хийсэн өдрийн дундаж /сард/	Хийдсэн гүйлгээний дундаж /сард/	Цуцалсан гүйлгээ /жилд/	Гүйлгээ хийсэн өдрийн дундаж /сард/	Хийдсэн гүйлгээний дундаж /сард/	Цуцалсан гүйлгээ /жилд/	Гүйлгээ хийсэн өдрийн дундаж /сард/	Хийдсэн гүйлгээний дундаж /сард/	Цуцалсан гүйлгээ /жилд/
Сумд	12	158	1181	13	186	1425	13	153	1881
Аймгийн төв	19	1785	1174	19	2093	1885	18	1540	1935

Төрийн сангийн хянах, батлах ажилтнууд төсөвт байгууллагууд эрсдэлтэй гүйлгээ хийхээс сэргийлэх зорилгоор суман хийгдсэн 4,487, аймагт хийгдсэн 4,994 гүйлгээг хууль, зааврын дагуу хянан буцааж, хэрэгжилтийг хангасан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Орон нутгийн хөгжлийн сан, Засаг даргын нөөц хөрөнгө болон Мал хамгаалах сангийн хөрөнгийг зарцуулах 1 дүгээр гарын үсэг зурах бүрэн эрхээ, хууль эрх зүйн зохицуулалтгүй албан тушаалтан болох Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.4³³, 4.1.38,³⁴ 37.1.1³⁵ дэх заалтуудыг зөрчиж төлбөр тооцоонд тавих хяналтыг алдагдуулах эрсдэлтэй байгаа учир зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн ОНТХО-ын сангийн зарлагын гүйлгээг анхан шатны баримтыг биечлэн хянахгүйгээр зөвхөн ЗДТГ-ын БНХОБТХ-ын хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний ирүүлсэн хяналтын хуудсыг үндэслэн гүйлгээ хийж байгаа нь төрийн сангийн үйл

³³ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

³⁴ "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг;

³⁵ төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;

ажиллагааны журмыг зөрчиж хяналтын чиг үүргийг сулруулж, дотоод хяналтын үйл ажиллагааг алдагдуулж байна. Энэ нь анхан шатны баримт нь хуурамч, дутуу эсвэл шаардлага хангаагүй тохиолдолд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, гүйцэтгэгч байгууллага болон хариуцсан мэргэжилтнүүд үгсэн хуйвалдах зэрэг эрсдэлийг бий болгох үр дагавартай.

Иймд аймгийн ОНТХО-ын сангийн зарлагын гүйлгээ бүрд гүйцэтгэлийн акт, нэхэмжлэх, гэрээний заалтыг хяналтын хуудастай тулган шалгасны үндсэн дээр гүйлгээг баталгаажуулж хэвших шаардлагатай байна.

Хүснэгт № 5 Төлбөр тооцооны хяналттай холбоотой зөрчлийн судалгаа /сая.төг/

Огноо	Нийт зөрчил		Үүнээс: Ангиллаар					
			Хууль тогтоомж зөрчсөн		Анхан шатны баримтын бүрдэл дутуу		Эдийн засгийн ангилал зөрчиж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан	
	Тоо	Дүн	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн
2023 он	109	329.8	9	21.8	58	174.1	42	133.9
2024 он	163	1,162.4	96	801.3	33	200.1	34	160.9
2025 он	120	2,249.2	53	1,952.0	32	83.6	35	213.7
Дүн	392	3,741.4	158	2,775.1	123	457.8	111	508.5

Эх сурвалж: Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023-2025 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн

Төсөл, сан болон төсөвт байгууллагуудын 2023-2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар төрийн сангийн хяналттай холбоотой зөрчлийн тоо сүүлийн 3 жилд өсөх хандлагатай байна. Хэдийгээр 2025 онд зөрчлийн тоо (120) өмнөх оноос бага зэрэг буурсан ч мөнгөн дүн нь 2,249.2 сая төгрөгт хүрч, 2023 онтой харьцуулахад 6.8 дахин, 2024 оноос 2 дахин өссөн нь эрсдэл өндөртэй, их хэмжээний дүнтэй зөрчлүүдээс урьдчилан сэргийлж чадахгүй байгааг харуулж байна. *Хүснэгт №*

График № 6 Зөрчлийн ангиллыг дүнд эзлэх хувиар харуулав.



Илэрсэн зөрчлийг агуулгаар нь авч үзвэл:

- **Хууль тогтоомжийн хэрэгжилт:** Нийт зөрчлийн дүнгийн 74.2%-ийг дангаараа эзэлж байгаа нь санхүүгийн сахилга бат, хууль, журмын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.
- **Анхан шатны баримтын бүрдэл:** Зөрчлийн тооны хувьд тогтворжиж байгаа

нь баримт бүрдүүлэлтийн процесс тодорхой хэмжээнд жигдэрсэн ч зөрчил бүрэн арилахгүй байна

- **Зориулалт бус зарцуулалт:** "Эдийн засгийн ангилал зөрчиж төсвийг зориулалт бусаар зарцуулсан" зөрчил жил бүр тогтмол өсөж байгаа нь санхүүгийн сахилга бат алдагдах, тайлангийн үнэн зөв байдал буурах, улмаар төрийн нөөцийн үр ашиггүй ашиглалт нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврыг бий

Хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг материаллаг дүнгээр авч үзвэл:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх батлагдсан төсөл, арга хэмжээг хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан 1,760.6 сая төгрөг
- Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, уралдаан тэмцээн зохион байгуулсан, дүрэмт хувцас худалдан авсан, видео контент нэвтрүүлэг бэлтгэсэн, амралтын газар сургалт зохион байгуулсан, гадаадад туршлага судлах арга хэмжээний байр, хоол, унааны зардлыг төлсөн зэрэг 96.9 сая төгрөгийн зөрчил байна.


Дээрх зөрчлүүдэд хийсэн дүн шинжилгээгээр төсөвт байгууллагуудын урсгал зардлын зарцуулалтад дотоод хяналт хангалтгүй, төсвийн сахилга бат алдагдсан нь зөрчлийн тоо, дүн өндөр гарахад нөлөөлсөн байна. Ялангуяа хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил ихэнх хувийн эзэлж байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалтын бусаар ашиглах эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Иймд төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан албан хаагчдыг холбогдох хууль, тайлагнал, эдийн засгийн ангилал, баримт бүрдүүлэлт, дотоод хяналтын чиглэлээр мэргэшүүлж, арга зүйгээр хангахын зэрэгцээ гүйлгээний баримт болон ангиллын нийцлийг журамд заасны дагуу нарийвчлан хянах ажлыг төрийн сангийн хүрээнд зохион байгуулах шаардлагатай байна.

Төсвийн байгууллагын бэлэн мөнгөний төлбөр тооцоо:

Аймгийн СТСХ 2023-2025 онд Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйл, 35 дугаар зүйлд заасан заалтуудын хүрээнд ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын арилжааны банкнуудад нээлгэсэн нийт 19 дансыг хаалгаж ажилласан байна. *График № 7*

График № 7 Хаагдсан дансны судалгаа



Аудитын явцад арилжааны банканд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур, зөвшөөрөлгүйгээр нээсэн данстай 4 төсвийн байгууллагын ашиглагдахгүй байгаа 3 данс, ашиглаж байгаа 1 дансанд төрийн сангаас тавих хууль тогтоомжид заасан хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11³⁶, 35 дугаар зүйлийн 35.3³⁷ 35 дугаар зүйлийн 35.4³⁸, 35 дугаар зүйлийн 35.5³⁹ заасныг тус тус зөрчсөн байна. Мөн төсвийн хөрөнгийн хөдөлгөөнийг хяналтгүй болгох, санхүүгийн ил тод байдал алдагдах, хууль зөрчсөн гүйлгээ гарах эрсдэлийг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

³⁶ Банканд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох;

³⁷ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ.

³⁸ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр ирүүлсэн зөвшөөрөлгүйгээр банк аливаа төсвийн байгууллагад данс нээхийг хориглоно.

³⁹ Банканд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ.

2.2.4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнасан байна.

Аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд ЗГ-ын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-д нийцүүлэн дараах тохируулгыг хийж тайлагнасан байна. Үүнд:

- 2023 онд өрхийн эмнэлэг болон ахмадын сантай холбоотойгоор
 - 886.1 сая төгрөгийн орлогын,
 - 894.4 сая төгрөгийн зардлын тохируулга;
- 2024 онд өрхийн эмнэлэг, ахмадын сан болон эргэлтийн сан татан буугдсантай холбогдуулан мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд
 - 978.4 сая төгрөгийн орлогын,
 - 1,033.5 сая төгрөгийн зардлын тохируулга;
- 2025 онд өрхийн эмнэлэг болон ахмадын сантай холбоотойгоор
 - 962.6 сая төгрөгийн орлогын,
 - 1,000.6 сая төгрөгийн зардлын тохируулга тус тус хийгдсэн байна.

2.3. Төрийн сангийн дотоод хяналтыг төлөвлөгөө, удирдамжийн дагуу тогтмол хэрэгжүүлж, тайлагнасан боловч илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэж, шалтгаан нөхцөл, эрсдэлийг үнэлэн үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүйгээс хяналтын үр нөлөө хангалтгүй, аудитын зөрчлийг бүүруулахад хангалттай нөлөөлөхгүй байна.

2.3.1. Төрийн сангийн дотоод, хөндлөнгийн болон дээд шатны байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэж, шалтгаан нөхцөлийг тодорхойлон үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүйгээс хяналтын үр нөлөө хангалтгүй, аудитын зөрчлийг бүүруулахад нөлөөлөхгүй байна.

Аймгийн төрийн сангийн дотоод хяналт: Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын 4.3-т заасны дагуу аймгийн Засаг даргын 2023 оны А/167 дугаар, 2024 оны А/158 дугаар, 2025 оны А/205 дугаар тоот захирамжаар дотоод хяналтын төлөвлөгөөг тус тус батлуулж, удирдамж боловсруулан төлөвлөгөөт дотоод хяналт хийсэн байна.

Дотоод хяналтыг сумын төрийн сангийн нэгжүүдээс ирүүлсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөн хэрэгжүүлж тайланг журмын дагуу Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

График № 8 Дотоод хяналтын хамрагдалт



Дотоод хяналтыг 2023, 2024 онуудад эрсдэлийн үнэлгээгээр 15 нэгжээс 9-ийг түүвэрлэн хийж байсан бол 2025 онд 11 нэгжийг биечлэн, 4 нэгжийг цахимаар шалгах замаар нэгжүүдийг бүрэн хамруулж шалгасан байна. Жил ирэх тусам дотоод хяналтын хамрагдалт нэмэгдэн хяналт цахимжиж шалгуур үзүүлэлтэд ногдох зөвлөмжийн тоо 2023-2025 онд 19-11 болж буурсан байна.

Хүснэгт № 6

Энэ нь нэгжүүдийн хариуцлага сайжирч, алдаа дутагдал буурч байгаа мэт боловч төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэх албан тушаалтнуудын гүйлгээний бодит агуулгын хяналт орхигдож анхан шатны баримттай холбоотой зөрчлүүд хяналт шалгалтаар давтагдан гарсаар байна.

Хүснэгт № 6 Дотоод хяналтын илрүүлэлт

№	Нэгжийн нэр	2023 он		2024 он		2025 он	
		Шалгуурын тоо	Зөвлөмжийн тоо	Шалгуурын тоо	Зөвлөмжийн тоо	Шалгуурын тоо	Зөвлөмжийн тоо
1	Дэлгэрцогт	8	6	18	13	11	6
2	Дэрэн	8	7	18	10	11	6
3	Говь-Угтаал	8	8	18	14	16	7
4	Цагаандэлгэр	8	8	18	16	16	12
5	Баянжаргалан					15	11
6	Өндөршил					15	6
7	Гурвансайхан	8	8	18	9	11	4
8	Өлзийт	8	8	20	17	10	9
9	Хулд	19	16	18	14	16	8
10	Луус	21	11	18	8	15	6
11	Дэлгэрхангай					15	8
12	Сайхан-Овоо					15	11
13	Эрдэнэдалай					15	5
14	Адаацаг					15	4
15	Сайнцагаан	21	19	18	11	15	11

Хяналт шалгалтыг төрийн сангийн нэгжүүдээс ирүүлсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөж хяналт хэрэгжүүлж байгаа боловч энэ нь хүлээгдэж буй үр дүнд хүрэхгүй байна. Одоогийн хяналтын механизм нь зөвхөн тухайн цаг үеийн зөрчлийг илрүүлэхэд чиглэж байгаа бөгөөд хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг өмнөх онуудын үзүүлэлттэй харьцуулан шинжилгээ хийх, хяналтын дараах үр нөлөөг тооцох ажил орхигдож байна. Үүнээс шалтгаалан санхүүгийн аудитаар илэрч байгаа төлбөр тооцооны хяналттай холбоотой зөрчлийн давтамж буурахгүй байна. Мөн дотоод хяналтыг төрийн сангийн нэгжүүд өөрсдийнх нь үнэлсэн эрсдэл үндэслэн хэрэгжүүлж байгаа байдал болон хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийж зөрчлийг бууруулах чиглэлээр цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүйтэй холбоотой байна.

Иймд давтагдан гарч байгаа зөрчлүүдийг нэгдсэн санд бүртгэн өгөгдлийн сан үүсгэж, зөрчлийн давтамж, хэлбэр, шалтгаан нөхцөлийг түүхэн өгөгдөл дээр суурилан харьцуулан

шинжилж, хяналтын төлөвлөлтийг журамд заасан шалгууртай хослуулан хийж дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

Сангийн яамны дотоод хяналт: 2025 онд СЯ-ны төрийн сангийн газраас Сангийн сайдын 2025 оны 56 тоот тушаалаар батлагдсан төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/101 тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ 2024-2025 оны төсвийн жилүүдэд хамаарах батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүжилт олгосон баримт, төрийн сангийн төлбөрийн баримтуудаас түүвэрлэн 19 заалтын хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.

Хяналтаар нэмэлт төсвийн зарцуулах эрх болон гүйлгээг журмын дагуу баримтжуулж, эдийн засгийн ангиллыг мөрдөн, өглөг авлагыг батлагдсан маягт ба ТСУЦС-ийн гүйцэтгэлтэй тулган хянаж, нягтлан бодогчийн зөвшилцөл болон бүрэн баримтад үндэслэн гүйлгээг баталгаажуулах, мөн арилжааны банк дахь төсвийн дансыг хаах замаар дотоод хяналтыг сайжруулах тухай зөвлөмж өгөгдсөн байна. Аймгийн СТСХ-ээс зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж, хариуг нотлох баримтын хамт аймгийн Засаг даргын 2025 оны 11 сарын 27-ны өдрийн 06/1594 дугаарт албан бичгээр хүргүүлсэн байна.

2.3.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж үр нөлөөтэй хэрэгжсэн байна.

2018 онд УАГ-ын нэгдсэн удирдамжаар “Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн”- сэдвийн хүрээнд гүйцэтгэлийн аудит хийгдэж тус аудитаар хууль журмын зарим заалтад өөрчлөлт оруулж сайжруулах асуудлаар УАГ-т 3 санал, аймгийн СТСХ-т 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг тулган шалгахад төрийн сангийн ажилчдын ашиглаж байгаа компьютерт вирусийн программ суулгах, тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх асуудлаар 2 зөвлөмжийг хэрэгжүүлэн заасан хугацаанд хариу ирүүлж, биелэлт 100.0 хувьтай байна. Харин 2026 онд хийж буй нийцлийн аудитаар дээрх зөвлөмжөөр өгөгдсөн асуудалтай холбоотой зөрчил илрээгүй, зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- ✓ Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, журмын зарим заалтууд хоорондоо уялдаагүй, хэрэгжүүлэх боломжгүй байна.
- ✓ Төрийн сангийн тогтолцоонд хараат байдал, хууль бус томилгоо болон хүний нөөцийн ачааллын тэнцвэргүй байдал зэрэг бүтцийн болон санхүүгийн эрсдэл үүссэн байна.
- ✓ Орон нутгийн Төрийн сангийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт бодит чиг үүрэгтэйгээ нийцээгүй, зарим суманд хууль бус болон хамааралгүй ажил үүрэг давхардуулсан зөрчилтэй байгаа төдийгүй сумдын ажлын ачаалал тэнцвэргүй байна.
- ✓ Төрийн сангийн цахим систем нь хэрэглэгчдийн ажлын үндсэн хэрэгцээг хангаж, аюулгүй байдал, ашиглахад хялбар байдлын хувьд боломжийн түвшинд байгаа боловч дутуу хөгжүүлэлт, интернэтийн хамаарал, цаасан баримтын давхардал, систем хоорондын уялдаа сул байна.
- ✓ Орон нутгийн төсөвт байгууллагууд болон сумдад олгох санхүүжилт төлөвлөгөөний дагуу бүрэн олгогдож байгаа боловч санхүүжилтийг олгох хугацааны хувьд холбогдох журмын хэрэгжилт бүрэн хангагдахгүй, үйл ажиллагааны дараалалтай холбоотой саатал үүсэж байна.
- ✓ Төсвийн зарцуулалтын эрх олголт журмын дагуу хэрэгжиж байгаа ч дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр төсөвт зохицуулалт хийсэн байна.
- ✓ Аймгийн төрийн сангийн гүйлгээний хяналт хангалттай хэмжээнд хийгдэж байгаа ч төлбөр тооцоонд тавих хяналт сул, ялангуяа хөрөнгө оруулалтын гүйлгээнд анхан шатны баримтад суурилсан хяналт хангалтгүй байна.
- ✓ Төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсөв хоорондын тооцоо болон холбогдох тохируулгын тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, тайлагнасан байна.
- ✓ Төрийн сангийн дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг нэгтгэн дүгнэж, нөхцөл шалтгааныг тодорхойлж, үр дүнг тооцон ажиллаагүйгээс дотоод хяналтын үр нөлөө хангалтгүй, аудитаар илэрсэн төрийн сангийн хяналттай холбоотой зөрчлийг бууруулахад нөлөөлөхгүй байна.
- ✓ Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж үр нөлөөтэй хэрэгжсэн байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

- **Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст**

1. Төрийн сангийн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг чиг үүрэгтэй нь уялдуулан шинэчлэгдсэн хууль, журмын шаардлагад нийцүүлж, давхардсан болон хамааралгүй чиг үүргийг хасаж, хяналт-шалгалтын бүрэн эрхийг тодорхой тусган, нэг бүрчлэн хянаж баталгаажуулах;
2. Төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан албан хаагчдыг холбогдох хууль, тайлагнал, эдийн засгийн ангилал, баримт бүрдүүлэлт, дотоод хяналтын чиглэлээр мэргэшүүлж, арга зүйгээр хангахын зэрэгцээ гүйлгээний баримт болон ангиллын нийцлийг журамд заасны дагуу нарийвчлан хянах ажлыг төрийн сангийн хүрээнд зохион байгуулах ;
3. Төсвийн зохицуулалтыг зөвхөн эрх бүхий албан тушаалтны ишийдвэр, зөвшөөрөлд үндэслэн, нарийвчилсан тооцоо, баримтаар баталгаажуулж хэрэгжүүлэх;
4. Дотоод хяналт, хөндлөнгийн хяналт болон дээд шатны байгууллагын хяналтаар илэрсэн зөрчилд дүн шинжилгээ хийж, үндсэн шалтгаанд суурилсан арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлж, хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх;



Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал

Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актуудын зарим заалтууд хоорондоо уялдаагүй, сайжруулах шаардлагатай, хэрэгжүүлэх боломжгүй байгаа тул УАГ-аар дамжуулан холбогдох байгууллагад уламжлах шаардлагатай дараах саналууд байна. Үүнд:

Санал 1:

Амлалтын бүртгэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор Төсвийн тухай хууль болон холбогдох журмын шаардлагад нийцсэн төрийн сан, төсөвт байгууллагуудын харилцааг зохицуулах шинэчилсэн журмыг баталж, мөн системд шаардлагатай бүртгэлийн талбаруудыг бүрэн тусган, хууль, зааврын хэрэгжилтийг хангах шаардлагатай.

Үндэслэл 1:

СЭЗС-ын 2003 оны 315 дугаар тушаалаар батлагдсан түр журам хүчингүй болсон боловч шинэ журам батлагдаагүй, мөн 2024 оны 256 дугаар тушаалаар батлагдсан зааварт заасан төлбөрийн амлалтын бүртгэлийн талбар системд бүрэн тусгагдаагүй байна. /Энэ талаар аудитын тайлангийн 9 дүгээр хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 2:

Орон нутгийн өмчит байгууллагуудын аудитлагдсан санхүүгийн тайланг хүргүүлэх болон сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланг илгээх хугацааг харилцан уялдуулан, холбогдох хуулийн зохицуулалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

Үндэслэл 2:

Төвийн тухай хуулийн 8.9.8.-д орон нутгийн өмчит байгууллагууд аудит хийгдсэн санхүүгийн тайлангаа 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяалагдах ТЕЗ-д хүргүүлж нэгтгүүлэхээр заасан боловч мөн хуулийн 8.9.3-т сумын төрийн сан нь санхүүгийн нэгтгэсэн тайланг 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ гэж заасан цаглаварт хугацаатай уялдаагүй байна.

Санал 3:

Төлбөрийн хүсэлтийн хүчинтэй хугацааг журмын дагуу ажлын 3 өдрөөр тооцох зохицуулалтад нийцүүлэн ТСЦ системийн хугацааны тохиргоог шинэчилж, амралтын өдрийг хасаж тооцохоор өөрчлөн хэрэгжилтийг хангах шаардлагатай.

Үндэслэл 3:

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.9, 3.4.10-т төлбөрийн хүсэлтийн хүчинтэй хугацаа болон гүйцэтгэлийг ажлын 3 өдрөөр тооцохоор заасан боловч ТСЦС /<https://finance.gov.mn/>-д уг хугацааг амралтын өдрийг оролцуулж 72 цагаар тооцож байгаа нь журмын заалтын хэрэгжилт хангагдахгүй байна.

Санал 4:

Ерөнхий нягтлан бодогч болон мэргэжилтний ажил үүргийг харилцан орлон гүйцэтгэх зохицуулалтыг албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээтэй нийцүүлэн дахин тодорхойлж, гарын үсгийн эрх, санхүүжилтийн шийдвэр гаргах болон тайлан баталгаажуулах үүргийг зөвхөн холбогдох эрх бүхий албан тушаалтанд хариуцуулан, хараат бус байдлыг хангах шаардлагатай.

Үндэслэл 4:

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан зааврын 1.2.18, 1.3.12-т төсвийн ерөнхий нягтлан бодогч болон мэргэжилтнүүд харилцан ажил үүргийг орлон гүйцэтгэхээр заасан нь албан тушаалын чиг үүргийн бодит хэрэгжилтэд нийцэхгүй, тухайлбал ерөнхий нягтлан бодогчийн эрхлэх 2 дугаар гарын үсэг зурах, санхүүжилтийн эрх олгох, тайлан баталгаажуулах зэрэг үүргийг мэргэжилтэн гүйцэтгэхэд хүндрэлтэй, боломжгүй бөгөөд хараат бус байдалд сөргөөр нөлөөлж байна.

Санал 5:

Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоол болон Соёлын яамны шийдвэрийн уялдаагүй зөрчлийг арилгах зорилгоор холбогдох эрх бүхий байгууллагаас зохицуулалтыг шинэчлэн нийцүүлэх, давхар санхүүжилтийг зогсоож, нэмэгдэл цалин олголтыг хууль, журмын дагуу нэг мөр болгох.

Үндэслэл 5:

Эрх бүхий байгууллагуудын шийдвэрийн уялдаагүй байдлаас шалтгаалан Засгийн газрын 326 дугаар тогтоолоор ЗДТГ-аас цалинждаг сумын нягтлан бодогчид Соёлын төвийн төсвөөс нэмэгдэл цалин давхардуулан олгож 2023-2025 онд 255.4 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан. /Энэ талаар аудитын тайлангийн 10 дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 6:

Төрийн сангийн дотоод хяналтын журам хоорондын зөрчлийг арилгаж, эрсдэлийн үнэлгээг хараат бусаар, бодитой хийх нэгдсэн эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэн, хяналт шалгалтыг эрсдэлд суурилан төлөвлөх замаар үр нөлөөг дээшлүүлэх.

Үндэслэл 6:

Төсвийн тухай хуулийн 36.6 болон Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан "эрсдэлд суурилсан хяналтын зарчим" нь Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар батлагдсан журмын 5.1.1 дэх заалттай (Сум, дүүрэг эрсдэлээ өөрөө үнэлэх) зөрчилдөж байна. /Энэ талаар аудитын тайлангийн 10 дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 7:

Төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний ажил үүргийг хэрэгжүүлж буй чиг үүрэгтэй нь уялдуулан тодорхой болгож, систем дэх эрхийн хуваарилалтыг төлбөрийн хүсэлтийн анхан шатны баримтыг тулган баталгаажуулах, төсвийн эрх, зориулалтын дагуу гүйлгээ гүйцэтгэх үндсэн чиглэлд нийцүүлэн шинэчлэн тогтоох шаардлагатай.

Үндэслэл 7:

Сангийн сайдын 2024 оны 256 дугаар тушаалаар батлагдсан зааврын 3.1-д Төрийн сангийн мэргэжилтний ажил үүргийг "Зардлын гүйлгээ нэмэх, хасах, устгах" гэж тодорхойлсон нь бодит чиг үүрэгтэй нийцэхгүй байна. /Энэ талаар аудитын тайлангийн 10-11 дүгээр дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 8:

Төсөв захирагч болон холбогдох албан тушаалтанд гарын үсгийн эрх, системд нэвтрэх эрх олгохдоо хуульд нийцсэн томилгоог баталгаажуулах шалгуурыг тодорхой болгож, эрх олголтыг зөвхөн хууль ёсны томилгоотой этгээдэд олгох зохицуулалтыг нарийвчлан тусган, системийн аюулгүй байдал болон хариуцлагын механизмыг сайжруулах шаардлагатай.

Үндэслэл 8:

Төсөв захирагч болон албан тушаалтанд гарын үсэг, системд нэвтрэх эрх олгох зохицуулалт тодорхой бус, хуульд нийцээгүй томилгоотой этгээдэд эрх олгогдох нөхцөл үүссэнээр төсвийн хөрөнгийн зарцуулалт, системийн аюулгүй байдал, хариуцлагын эрсдэл нэмэгдэж байна. /Энэ талаар аудитын тайлангийн 11 дүгээр хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 9:

Санхүү, төрийн сангийн хэлтэс болон сумдын санхүүгийн албыг Засаг даргын тамгын газрын бүтцээс гаргаж, Сангийн яамны харьяалалд шилжүүлэх замаар төрийн сангийн үйл ажиллагааны хараат бус байдал, хяналтын үр нөлөө, төсвийн сахилга батыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

Үндэслэл 9:

Төрийн сангийн хэлтэс, албад нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын (ЗДТГ) бүтцэд харьяалагдаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 36.2 дахь заалтад "ЗДТГ-ын дэргэд байна" гэж заасныг зөрчиж байна. /Энэ талаар аудитын тайлангийн 12-13 дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 10:

Аймаг, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд ажлын ачаалал, орон тооны тэнцвэргүй байдлыг арилгах зорилгоор бүтэц, орон тоог оновчтой шинэчлэн, гүйлгээг автоматжуулах, эрсдэлд суурилсан хяналтыг нэвтрүүлэх, нэгжүүдийг бүсчлэн зохион байгуулах, мөн сул орон тоог хууль, журмын дагуу нөхөх замаар хүний нөөцийн ашиглалтыг сайжруулж, зардлыг бууруулах.

Үндэслэл 10:

Аймаг, сумдын төсөв төрийн сангийн мэргэжилтний ажлын ачаалал харилцан адилгүй сумдын хувьд үндсэн ажлын ачаалал бага, хянаж, баталгаажуулсан гүйлгээг 6 сарын дунджаар сумын мэргэжилтний гүйлгээнд зарцуулж байгаа хоногийн тоо аймгийн төвийн мэргэжилтнээс 1.5 дахин бага, гүйлгээний тоо 10.9 дахин бага ачаалалтай ажиллаж байна. /Энэ талаар аудитын тайлангийн 14, 15-16 дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./

Санал 11:

Төрийн сангийн цахим систем нь төрийн сангийн хэрэглэгчдийн хувьд хүртээмж, аюулгүй байдал хангагдсан ч дутуу хөгжүүлэлт, цаасан баримтын давхардал зэрэгт анхаарал хандуулж системийн сайжруулалт, журамд нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Үндэслэл 11:

Төрийн сан болон төсөвт байгууллагын хэрэглэгчээс авсан санал асуулгын дүнгээс харахад Төрийн сангийн цахим систем нь төрийн сангийн хэрэглэгчдийн хувьд хүртээмж, аюулгүй байдал хангагдсан ч дутуу хөгжүүлэлт, цаасан баримтын давхардал зэрэгт анхаарал хандуулж системийн сайжруулалт, журамд нэмэлт өөрчлөлтийг хийх шаардлагатай байгааг харуулж байна. /Энэ талаар аудитын тайлангийн 17-20 дугаар хуудсанд дэлгэрэнгүй оруулсан./



Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

С. Буяннамэхийн өргөн чөлөө 2-211 тоот, 7 дугаар баг,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48090 Утас: 7059 2494
Цахим шуудан: info@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2026.05.28 № 06/859

танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Д.Цхдагч
Төрийн сангийн хэлтсийн дарга
80079

“Төрийн сангийн тогтолцоо, хууль журмын нийцэл”-д нийцлийн аудит хийж гүйцэтгэсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Санал тайлбар байхгүй.

СТСХ-ИЙН ТӨСВИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТНИЙ АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *М.Янжиндолгор* М.ЯНЖИНДОЛГОР



4836260408

ТӨРИЙН САНГИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЛБАН ХААГЧ, БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН СУДАЛГАА /ДУНДГОВЬ /

№	Төрийн сангийн чиг үүрэг харьяалагдаж байгаа нэгжийн нэр	Төрийн сангийн чиг үүрэг гүйцэтгэх албан тушаалын нэр /АТТ батлагдсанаар/	Төрийн сан хариуцсан албан хаагчийн нэр	Албан тушаалын			Тус албан тушаалд ажилласан жил /1 жилээс доош 1-3 жил 3-5 жил 5-аас дээш/	Тайлбар
				Төрөл	Ангилал	Зэрэглэл		
А	1	2	3	4	5	6	7	8
1	Санхүү, төрийн сангийн хэлтэс	СТСХ-ийн дарга	Н.Сүхбаатар	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-4	1 жилээс доош	
2	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Г.Энхтайван	ТЗ	Ахлах түшмэл	ТЗ-7	1 жилээс доош	
3	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсвийн ерөнхий нягтлан бодогч	С.Адьяасүрэн	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-6	3-5 жил	
4	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төсвийн орлого хариуцсан мэргэжилтэн	Ж.Баярсайхан		Дэс түшмэл	ТЗ-7	3-5 жил	
5	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн	Ц.Даваа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
6	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн	Г.Мөнхбаясгалан	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	3-5 жил	
7	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	Т.Урангуа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	3-5 жил	
8	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	М.Янжиндолгор	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1-3 жил	
9	Адаацаг сумын санхүүгийн алба	Санхүүгийн албаны дарга	Э.Баяржаргал	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	

10	Адаацаг сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Ц.Алтансарнай	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	5-аас дээш	
11	Баянжаргалан сумын санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Т.Дуламханд	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
12	Баянжаргалан сумын санхүүгийн алба	Төсөв Төрийн сангийн мэргэжилтэн	Д.Алтангэрэл	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1 жилээс доош	
13	Говь-Угтаал сумын санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Н.Ганбат	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	3-5 жил	
14	Говь-Угтаал сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Н.Болор-Эрдэнэ	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1-3 жил	
15	Гурвансайхан сумын санхүүгийн алба	Санхүүгийн албаны дарга	Д.Баярцэнгэл	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	1-3 жил	
16	Гурвансайхан сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	ТУрангуа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	3-5 жил	<i>Аймгийн СТСХ-ийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Т.Урангуа Гурвансайхан сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг 2025.01.20.-ны өдрөөс албан тушаалын цалингийн 40 хувиар цалин хөлс авч хавсран гүйцэтгэж байна.</i>
17	Дэлгэрхангай сумын санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Ч.Батхуяг	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
18	Дэлгэрхангай сумын санхүүгийн алба	Төрийн сангийн мэргэжилтэн	Я.Бямбаогтох	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	5-аас дээш	
19	Дэлгэрцогт сумын санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Ч.Баярмаа	ТЗ	Ахлах түшмэл	ТЗ-7	3-5 жил	
20	Дэлгэрцогт сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	М.Янжиндолгор	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1-3 жил	<i>Аймгийн СТСХ-ийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн М.Янжиндолгор Дэлгэрцогт сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг 2025.01.21.-ны өдрөөс албан тушаалын цалингийн 40</i>

								хувиар цалин хөлс авч хавсран гүйцэтгэж байна.
21	Дэрэн сумын санхүүгийн алба	Санхүүгийн албаны дарга	С.Цэрэнрагчаа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
22	Дэрэн сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	С.Мөнхтуяа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	5-аас дээш	
23	Луус сумын санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Б.Доржханд	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
24	Луус сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Б.Бүжинлхам	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1-3 жил	
25	Өлзийт сумын санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Б.Болдбаатар	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
26	Өлзийт сумын санхүүгийн алба	Төсөв Төрийн сангийн мэргэжилтэн	М.Янжиндолгор	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1 жилээс доош	Аймгийн СТСХ-ийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн М.Янжиндолгор Өлзийт сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг 2026.04.01.-ны өдрөөс албан тушаалын цалингийн 40 хувиар цалин хөлс авч хавсран гүйцэтгэж байна.
27	Өндөршил сумын санхүүгийн алба	Санхүүгийн албаны дарга	Х.Хундмаа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
28	Өндөршил сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Ө.Отгонгэрэл	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1 жилээс доош	
29	Сайнцагаан сумын Санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Б.Уранжаргал	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	3-5 жил	
30	Сайнцагаан сумын Санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	У.Базармаа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	1-3 жил	
31	Сайхан-Овоо сумын санхүүгийн алба	Санхүүгийн албаны дарга	Р.Тунгалагтуяа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
32	Сайхан-Овоо сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	А.Ралжигмаа	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн Сайхан-Овоо сум хариуцсан мэргэжилтэн А.Ралжигмаа төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг 2024.10.01.-ны өдрөөс албан тушаалын цалингийн 40 хувиар цалин хөлс авч, 2026.01.01.-нээс цалин хөлсгүй гүйцэтгэж байна.

33	Хулд сумын санхүүгийн алба	Санхүү албаны дарга	Э.Хонгорзул	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	3-5 жил	
34	Хулд сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	С.Сүхдорж	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	3-5 жил	
35	Цагаандэлгэр сумын санхүүгийн алба	Санхүүгийн албаны дарга	Н.Батгэрэл	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	1-3 жил	
36	Цагаандэлгэр сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Д.Бат-Орших	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-9	1 жилээс доош	<i>Цагаандэлгэр сумын ЖДҮХоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Бат-Орших сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг 2026.03.23.-ны өдрөөс албан тушаалын цалингийн 40 хувиар цалин хөлс авч хавсран гүйцэтгэж байна.</i>
37	Эрдэнэдалай сумын санхүүгийн алба	Санхүүгийн албаны дарга	А.Соёл-Эрдэнэ	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-7	5-аас дээш	
38	Эрдэнэдалай сумын санхүүгийн алба	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Ж.Бадамцэцэг	ТЗ	Дэс түшмэл	ТЗ-8	5-аас дээш	

Хавсралт №.2:

ҮНДСЭН АЖИЛТАЙГАА ЗЭРЭГЦҮҮЛЭН ДАВХАР АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУДАЛГАА /ДУНДГОВЬ /

№	Төрийн сан хариуцсан албан хаагчийн нэр	Харьяалагдаж буй байгууллага	Албан тушаалын нэр	Хавсран гүйцэтгэдэг албан тушаалууд		
				Байгууллагын нэр	Албан тушаал	Түр орлон гүйцэтгэгч/ үндсэн орон тоонд ажиллаж байгаа эсэх
А	1	2	3	4	5	6
1	Г.Энхтайван	Аймгийн СТСХ	Төсвийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Санхүүгийн зохицуулах хороо	Орон нутаг дахь төлөөлөгч	Үгүй
2	Г.Мөнхбаясгалан	Аймгийн СТСХ	Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн	Санхүүгийн зохицуулах хороо	Орон нутаг дахь төлөөлөгч	Үгүй
3	Т.Урангуа	Аймгийн СТСХ	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	Гурвансайхан сумын ЗДТГ	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Түр орлон гүйцэтгэгч
4	М.Янжиндолгор	Аймгийн СТСХ	Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн	Дэлгэрцогт, Өлзий сумын ЗДТГ	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Түр орлон гүйцэтгэгч
5	Н.Болор-Эрдэнэ	Говь-Угтаал сумын ЗДТГ	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Говь-Угтаал сумын ЗДТГ	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	Түр орлон гүйцэтгэгч
6	Ц.Алтансарнай	Адаацаг ЗДТГ	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Адаацаг ЗДТГ	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	Түр орлон гүйцэтгэгч
7	С. Мөнхтуяа	Дэрэн ЗДТГ	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	Дэрэн ЗДТГ	Жижиг дунд, хоршоо хариуцсан мэргэжилтэн	Түр орлон гүйцэтгэгч

**ТӨРИЙН АЖИЛТНУУДЫН ТӨРИЙН САНГИЙН ГҮЙЛГЭЭНИЙ ХЯНАЛТАД ЗАРЦУУЛАХ
АЧААЛЛЫН СУДАЛГАА /ДУНДГОВЬ /**

Үзүүлэлт	Албан хаагчийн тоо		2023 он		2024 он		2025 он	
	Батлах	Хянах	Өдрийн дундаж	Гүйлгээний дундаж	Өдрийн дундаж	Гүйлгээний дундаж	Өдрийн дундаж	Гүйлгээний дундаж
Адаацаг сум	1	1	12	139	12	163	16	119
Баянжаргалан сум	1	1	11	93	14	139	12	107
Говь-Угтаал сум	1	1	12	116	13	123	15	99
Гурвансайхан сум	1	1	11	151	13	176	13	134
Дэлгэрцогт сум	1	1	13	151	12	178	13	157
Дэрэн сум	1	1	12	136	13	177	12	142
Дэлгэрхангай сум	1	1	12	132	14	172	16	168
Өлзийт сум	1	1	12	140	14	183	11	112
Өндөршил сум	1	1	13	157	13	159	13	128
Сайхан-Овоо сум	1	1	11	127	11	106	10	79
Хулд сум	1	1	14	142	14	137	15	134
Луус сум	1	1	12	148	12	144	11	117
Цагаандэлгэр сум	1	1	12	116	13	108	15	101
Эрдэнэдалай сум	1	1	12	143	14	225	13	203
Сайнцагаан сум	1	1	17	489	18	600	16	491
Сумдын дүн	15	15	183	2377	196	2789	201	2290
Аймгийн төв	1	2	19	1785	19	2093	18	1540
Нийт дүн	16	17	202	4162	215	4882	218	3831

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сум, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 